



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/76/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь 2018 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
	Утас:7052-2734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	Ц.Лүндэгмаа
	Утас: 7052-3020	Цахим хаяг:
	Аудитор:	Б.Байгал
	Утас: 99359854	Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	6
2.1	Оршил.....	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА
2019. 02. 27 № 1-6/235	
танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлт	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод</p>	

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал:

- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 59851,7 мянган төгрөгийг зарцуулахдаа засаг даргын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэргүй захирамж гарган зарцуулсан, 27543,9 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй худалдан авалт хийсэн, 31109,0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлээгүй журам зөрчсөн байна.
- Батлагдсан төсвийн санхүүжилтаар худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна. Нийт 51035,4 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж хууль зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан "Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1. Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна, 5.1. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно, 2.3. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно, Төсвийн тухай хуулийн 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 24 тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 " төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах

ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын ЗДТГ-ын дарга Ш.Чулуунцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.12-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт "Мөнгө Нөөц Баялаг аудит" ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт "Мөнгө Нөөц Баялаг аудит" ХХК-д 2019.02.12-ны өдрийн 3/169 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын ЗДТГ нь Хүний хөгжлийг дээдэлсэн, амьдрах таатай орчин бүрдүүлсэн, байгаль, орчинд ээлтэй, аж үйлдвэрлэл, аялал жуулчлалаар тэргүүлэгч, эдийн засгийн өндөр чадавхтай, хөгжлийн тулгуур хот болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Сумын ИТХ-ийн 2018 оны батлагдсан төсөв

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын даргын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 10 тоот захирамжаар Бодлогын баримт бичиг, журам батлах тухай захирамж гарсан байна. Уг баримт бичгийн эрх зүйн үндэслэл хэсэгт УСНББОУС-ыг тусгаагүй мөн Сангийн сайдын 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврыг өөрийн онцлогт тохируулан тусгах шаардлагатай байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "ACOLOUS" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 1 хувиар сонгов.

Нийт орлого -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материал байдлын суурийг төлөвлөлтийн явцад орлогоор сонгосныг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ 2018 оны *Нийт орлого* 29,356.28 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 29,356.28 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт орлогын 1 хувиас давсан алдааг материаллаг алдаа гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	184,843.60	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	184,843.60	

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар, төсвийн эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан эсэх,

Засаг даргын нөөц сангийн зарцуулалт түүний шийдвэр

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 886866.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт төсөв 2019 оны 12 дугаар сард хийгдсэн тодотголоор үйл ажиллагааны санхүүжилт 987169,4 мянган төгрөг, Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 191923,2 мянган төгрөг орон нутгийн нөөц хөрөнгө 114428,9 мянган төгрөг нийт 1293521,5 мянган төгрөг тайлант жилд 27131,6 мянган төгрөгийн хэмнэлтийг татан төвлөрүүлсэн байна.

Төсөв хэмнэгдсэн шалтгаан нь батлагдсан төсвийг илүү баталсантай холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх тайланд хөрөнгө бүртгэх зөвлөмж өгсөн боловч хариу хүргүүлсэн ба 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 59851,7 мянган төгрөгийг зарцуулахдаа засаг даргын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэргүй захирамж гарган зарцуулсан, 27543,9 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй худалдан авалт хийсэн, 31109,0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлээгүй журам зөрчсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1. Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна, 5.1. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно, 2.3. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана.

Эрсдэл

1. Хөрөнгө үнэгүйдэх, хэмнэлтгүй зарцуулах эрсдэлтэй

Зөвлөмж

Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг мөрдөж ажиллах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын Дарга Ш.Чулуунцэцэг, нягтлан бодогч Ц.Адъяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Батлагдсан төсвийн санхүүжилтээр худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна. Нийт 51035,4 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж хууль зөрчсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно, Төсвийн тухай хуулийн 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

1. Хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдах

Зөвлөмж

Худалдан авах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын Дарга Ш.Чулуунцэцэг, нягтлан бодогч Ц.Адъяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Жолоочийн дагалдах хуудсыг бөгөлдөг боловч сар бүр тооцоог бодож бүртгэлээр тавих хяналтыг орхигдуулсан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Шатахууны тооцооны хуудсыг сар бүр тооцож жолооч бүрээр зарцуулалтыг тооцож байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГ-ын Дарга Ш.Чулуунчимэг, нягтлан бодогч Ц.Адъяа

Эрсдэл

1. Анхан шатны дэмжих баримтгүй ажил гүйлгээг бүртгэсэн эсэх

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ЛҮНДЭГМАА

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.БАЙГАЛ

Огноо:

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>127,292,716.37</u>	<u>198,745,932.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	13,959,757.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	13,959,757.00
3121	Төгрөг	00.00	13,959,757.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	13,959,757.00
33	АВЛАГА	11,661,500.00	435,600.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,307,420.00	00.00
335	Бусад авлага	9,354,080.00	435,600.00
3351	Байгууллагаас авах авлага	9,354,080.00	435,600.00
34	УРЬДЧИЛГАА	6,920,000.00	6,920,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	6,920,000.00	6,920,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920,000.00	6,920,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	108,711,216.37	177,430,575.70
351	Түүхий эд материал	10,150,213.50	101,848,913.50
35110	Тусгай зориулалттай материал	10,150,213.50	101,848,913.50
354	Хангамжийн материал	98,561,002.87	75,581,662.20
35410	Бичиг хэргийн материал	7,935,425.00	6,386,500.00
35420	Аж ахуйн материал	65,249,194.87	48,905,841.20
35430	Сэлбэг хэрэгсэл	3,945,000.00	5,861,227.00
35440	Түлш, шатах тослох материал	4,086,883.00	1,417,864.00
35470	Бусад хангамжийн материал	17,344,500.00	13,010,230.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,415,266,152.74</u>	<u>7,669,265,373.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,415,266,152.74	7,669,265,373.53
392	Биет хөрөнгө	8,408,347,749.91	7,319,911,178.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,676,969,209.35	2,140,771,430.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-748,146,601.73	-5,548,820.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,334,800.00	137,334,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,780,416.53	-72,719,272.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,619,286.44	166,749,286.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,594,080.29	-119,970,686.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,619,354.64	104,943,954.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,342,921.50	-49,398,718.91
39209	Зам, гүүрийн байгууламж	4,994,154,973.88	2,568,617,697.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-558,126,108.16	-50,123,524.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,991,177,242.00	2,971,809,401.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	-128,407,188.19	-474,424,568.45
39217	Ном	1,870,200.00	1,870,200.00
393	Биет бус хөрөнгө	6,918,402.83	349,354,194.69
39301	Програм хангамж	13,434,000.00	13,764,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,618,722.07	-8,475,805.31
39303	Бусад биет бус хөрөнгө	550,000.00	344,616,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-446,875.10	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,542,558,869.11</u>	<u>7,868,011,306.23</u>

Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,388,602.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,388,602.00	00.00
413	Өглөг	5,388,602.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,537,170,267.11</u>	<u>7,868,011,306.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,537,170,267.11	7,868,011,306.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,447,848.97	593,513,848.97
51101	Өмч: - төрийн	249,447,848.97	593,513,848.97
512	Хуримтлагдсан үр дүн	8,278,859,396.03	6,850,982,824.84
51210	Өмнөх үеийн үр дүн	8,278,859,396.03	8,278,859,396.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,863,022.11	1,427,876,571.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,542,558,869.11</u>	<u>7,868,011,306.23</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,531,742,243.30	2,935,627,935.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,138,100,763.30	1,941,674,799.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,138,100,763.30	1,941,674,799.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,138,100,763.30	1,941,674,799.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,495,500.00	16,642,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,136,605,263.30	1,925,032,799.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,641,480.00	993,953,136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,064,280.00	101,622,066.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,359,019.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	39,760,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,511,780.00	48,983,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	552,500.00	11,519,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	312,577,200.00	892,331,070.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	312,577,200.00	892,331,070.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,895,443,506.83	1,573,683,531.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,895,443,506.83	1,573,683,531.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,895,443,506.83	1,522,004,997.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,397,126.00	580,590,815.00
210101	Үндсэн цалин	190,092,119.00	454,859,889.00
210104	Урамшуулал	13,860,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	51,445,007.00	125,730,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,459,721.00	67,389,544.00
210201	Тэтгэврийн даатгал	18,539,068.00	53,799,401.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,984,130.00	2,926,767.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,480,163.00	3,658,459.00
210204	Ажилгүйдлийн даатгал	496,032.00	731,691.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,960,328.00	6,273,226.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,096,044.00	48,474,521.60
210301	Гэрэл, цахилгаан	3,322,085.00	6,605,357.00
210302	Түлш, халаалт	13,719,740.00	29,225,136.60
210303	Цэвэр, бохир ус	1,554,219.00	3,874,727.00
210304	Байрны түрээс	2,500,000.00	8,769,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,980,916.64	157,968,315.71
210401	Бичиг хэрэг	9,036,620.40	19,337,770.00
210402	Тээвэр, шатахуун	11,692,780.00	41,236,455.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,758,551.91	9,013,244.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00

Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,655,666.00	65,482,056.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,409,930.00	00.00
210408	Бараа материал ахталсны зардал	15,187,368.33	22,658,790.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	487,800.00	4,654,725.00
210604	Урсгал засвар	487,800.00	4,654,725.00
2107	Томилолт, зочны зардал	4,064,800.00	2,515,200.00
210701	Гадаад албан томилолт	00.00	106,500.00
210702	Дотоод албан томилолт	4,064,800.00	2,408,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,394,962.37	89,473,985.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,940,362.37	88,849,385.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	236,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	215,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	162,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	11,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,425,562,136.82	570,937,890.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	841,500.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,424,720,636.82	570,937,890.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	51,678,534.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	24,370,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	23,670,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	27,297,534.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,297,534.24
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	11,000.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	11,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	636,298,736.47	1,361,944,403.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,420,073.52	2,789,820,974.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,420,073.52	1,409,852,270.14
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,379,968,704.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,420,073.52	-2,789,820,974.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	620,878,662.95	-1,427,876,571.19

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	967,365,492.38	1,019,692,836.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,560,984.00	16,642,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,560,984.00	16,642,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,560,984.00	16,642,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,560,984.00	16,642,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,804,508.38	1,003,050,836.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,899,432.00	110,719,766.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,359,019.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	39,760,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	137,499,032.00	48,983,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,400,400.00	20,617,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	807,905,076.38	892,331,070.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	807,905,076.38	892,331,070.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	957,685,492.38	979,598,479.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,685,492.38	979,598,479.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	911,487,792.38	926,777,101.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,955,817.81	580,590,815.00
210101	Үндсэн цалин	385,690,413.41	438,588,555.00
210104	Урамшуулал	34,590,435.00	397,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	99,674,969.40	141,604,760.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,320,414.00	71,287,684.00
210201	Тэтгэврийн даатгал	36,080,264.00	47,525,123.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,048,028.00	5,940,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,060,036.00	4,752,512.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,012,008.00	1,188,128.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,120,078.00	11,881,281.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,706,358.40	48,474,521.60
210301	Гэрэл, цахилгаан	6,799,845.00	6,570,513.00
210302	Түлш, халаалт	24,738,943.00	29,297,457.60
210303	Цэвэр, бохир ус	3,467,570.40	3,837,250.00
210304	Байрны гүрээс	6,700,000.00	8,769,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,744,281.06	55,040,388.14
210401	Бичиг хэрэг	16,846,974.40	15,303,768.00
210402	Тээвэр, шатахуун	32,060,163.00	24,874,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,860,468.66	9,974,595.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	240,000.00	240,000.00

Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,736,675.00	4,647,565.00
2105	Нормативт зардал	2,490,000.00	400,000.00
210502	Хоол, хүнс	2,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	490,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,007,685.00	10,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,035,000.00	00.00
210602	Тавилга	527,000.00	00.00
210604	Урсгал засвар	21,445,685.00	10,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,116,056.00	2,515,200.00
210702	Дотоод албан томилолт	7,116,056.00	2,515,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,226,580.11	157,968,493.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,715,030.11	157,343,893.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	236,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	215,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,550.00	162,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	11,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,920,600.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	478,400.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,442,200.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,197,700.00	52,821,377.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,100,000.00	25,088,243.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	23,670,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	818,243.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,100,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,097,700.00	27,297,534.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,097,700.00	27,297,534.24
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	435,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	435,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,680,000.00	40,094,357.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,680,000.00	26,134,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,680,000.00	26,134,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,680,000.00	26,134,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,680,000.00	26,134,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,680,000.00	-26,134,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	13,959,757.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	13,959,757.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,447,848.9 7	8,863,022.11	32,163,679,642.8 9	32,421,990,513.9 7
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	- 24,484,527,023.7 5	- 24,484,527,023.7 5
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,447,848.9 7	8,863,022.11	7,679,152,619.14	7,937,463,490.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	620,878,662.95	620,878,662.95
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,447,848.9 7	8,863,022.11	8,278,859,396.03	8,537,170,267.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,447,848.9 7	8,863,022.11	8,278,859,396.03	8,537,170,267.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	414,651,610.3 1	00.00	414,651,610.31
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	344,066,000.0 0	00.00	- 1,427,876,571.19	- 1,083,810,571.19
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.9 7	423,514,632.4 2	6,850,982,824.84	7,868,011,306.23

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	886,866,600.00	893,035,070.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	886,866,600.00	893,035,070.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,866,600.00	865,737,535.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	558,712,300.00	555,277,668.00
210101	Үндсэн цалин	411,832,300.00	413,672,908.00
210105	Гэрээт ажлын хөлс	146,880,000.00	141,604,760.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,120,900.00	71,287,684.00
210201	Тэтгэврийн даатгал	46,747,266.00	47,525,123.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,843,408.00	5,940,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,674,727.00	4,752,512.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,168,682.00	1,188,128.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,686,817.00	11,881,281.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,885,400.00	48,474,521.60
210301	Гэрэл, цахилгаан	7,690,000.00	6,570,513.00
210302	Түлш, халаалт	30,018,800.00	29,297,457.60
210303	Цэвэр, бохир ус	5,676,600.00	3,837,250.00
210304	Байрны түрээс	9,500,000.00	8,769,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,397,900.00	55,040,388.14
210401	Бичиг хэрэг	14,986,200.00	15,303,768.00
210402	Тээвэр, шатахуун	24,231,700.00	24,874,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,540,000.00	9,974,595.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.00	4,647,565.00
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00

Сайншанд сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	11,000,000.00
210602	Тавилга	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	10,500,000.00	10,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,096,600.00	2,515,200.00
210702	Дотоод албан томилолт	3,096,600.00	2,515,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,253,500.00	121,742,074.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,628,900.00	121,117,474.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	236,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	215,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	162,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	11,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	886,866,600.00	893,035,070.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	884,866,600.00	892,331,070.00
132001	Орон нутгийн төсвөөс	884,866,600.00	892,331,070.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	704,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	704,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	89.00	89.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00
620004	Гэрээт ажилтан	36.00	36.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,698,009.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,698,009.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,174,166.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,313,147.00
210101	Үндсэн цалин	24,915,647.00
210104	Урамшуулал	397,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,304,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,304,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,556,419.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,556,419.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25088243.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,088,243.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	23,670,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	818,243.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	435,600.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	435,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	110719766.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,719,766.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,359,019.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,760,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,983,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,617,600.00